



“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026 оны 02 дугаар сарын 09

Улаанбаатар хот

**Нэг.Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, Засгийн газарт хэрэгжилтийг тайлагнах, яамны удирдлага, албан тушаалтныг мэдээллээр хангах, үр дүнг сайжруулах зөвлөмж өгөх, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалаар тооцож, үр дүнг 6.5-д заасны дагуу дүгнэсэн.

**Хоёр.Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, хийх журам”-ын дагуу үнэлэхэд Зам, тээврийн сайдын дангаараа хэрэгжүүлэх 54 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 65.3 хувь, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн өссөн дүн 45.9 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн нийт үнэлгээ 100 хувь, хөтөлбөрийн үр дүн 85.6 хувийн үнэлгээтэй байна.

Мөн хөтөлбөрийн холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 26 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.2 хувийн үнэлгээтэй байна.

2.1. Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж 0-29 хувьтай буюу “үр дүн гараагүй” арга хэмжээг Хүснэгт №1-д харуулав.

*“0-29” хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээ*

*Хүснэгт №1*

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	683	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой, Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл-Уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	0	10	0.01	0.1%
2	684	Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	49	70	55	28.6%



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

3	692	Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	47	100	55	15%
---	-----	--	--------------------------------	----	-----	----	-----

2.2. Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж 30-59 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүн хангалтгүй” арга хэмжээг Хүснэгт №2-т харуулав.

*“30-59” хувийн хэрэгжилттэй төсөл, арга хэмжээ*

*Хүснэгт №2*

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	620	Тээврийн ерөнхий хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	0	100	30	30%
2	646	Олон улс, улсын чанартай 936 км хатуу хучилттай авто зам, 20 байршилд 3030.7 у/м гүүрний их засвар, шинэчлэлт хийх	Их засварын гүйцэтгэл, хувь	0	20	10	50%
3	650	Олон улс, улсын чанартай авто замд уламжлалт төлбөр авах цэг 8, цахим цэг 12 байршилд барих	Шинээр ашиглалтад орсон төлбөр авах цэг, тоо	32	2	50	50%
4	651	Төмөр замын тээврийн үнэ тарифыг тооцох аргачлал гаргах	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	0	100	30	30%
5	667	Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	0	10	5	50%
6	688	Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	70	100	84	46.7%

2.3. Төсөл, арга хэмжээний “шалгуур үзүүлэлт” нь “барилгын ажлын гүйцэтгэл”-ийн хувиар тооцохоор батлагдсан доорх 16 төсөл, арга хэмжээ нь одоогоор ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Иймд дээрх 16 төсөл, арга хэмжээг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалын дагуу үнэлэх боломжгүй байгаа тул хэрэгжилтийн явцыг харгалзан 30-59 хувиар үнэлэн Хүснэгт №3-д харуулав.

*Шалгуур үзүүлэлтээс хамаарч 30-59 хувиар үнэлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт*

*Хүснэгт №3*

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Батлагдсан шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1. Төмөр замын салбар				

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

1	59	“Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/37 дугаар тушаалаар байгуулсан Үнэлгээний хороо Хөнгөн галт тэрэгний LRT төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарласан боловч одоогоор шаардлагад нийцсэн тендер ирээгүй байна.
2	616	Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Монголын төмөр зам ТӨХК Бичигт-Зүүнхатавч хил дамнасан төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулж ЗТЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж авсан. ТЭЗҮ-г сайжруулахаар ажиллаж байна. Мөн БНХАУ-ын Улсын төмөр замын газарт 2025.06.19-ний өдрийн 01/77 тоот албан бичгээр Монгол, Хятадын Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замыг холбох асуудлыг дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал, эдийн засгийн үр өгөөж, ач холбогдолыг харилцан судлах, хилийн боомтуудыг эрэмбэлэн, үе шаттай төлөвлөн бүтээн байгуулах ажлын хүрээнд судалгааны ажлыг зэрэг эхлүүлэх, хамтарч урагшлуулах дэмжлэг үзүүлэх хүсэлт хүргүүлсэн.
3	628	Эрэнцав-Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замын их засвар хийх;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	УБТЗ-ын Ерөнхий инженерийн орлогчийн 2023.03.06-ны өдрийн Упр 59-Б цахилгааны дагуу Зураг төслийн төвийн инженер техникийн ажилтнууд 2023 оны 03-р сарын 18-23-ны өдрүүдэд Эрэнцав өртөөнөөс Баянтүмэн өртөө хоорондын замд зам шинэчлэлтийн их засварын ажлын зураг төслийн хээрийн хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн өгөгдлийн дагуу 238 км замын их засварын иж бүрэн зураг төсөл, төсвийг боловсруулсан. 2024 оны Замын их засварын ажлыг гүйцэтгэх санхүүжилтэд 5.6 тэрбум төгрөг тавигдсан. Мөн Эрэнцав – Баянтүмэн чиглэлийн төмөр замын шугамыг Хөөт-Бичигт, Хөөт – Чойбалсан чиглэлийн шинээр байгуулагдах төмөр замын шугамтай холбон ачааг тээвэрлэх хүрээнд шинэчлэн хүчжүүлэх арга хэмжээний техникийн нөхцөлийн урьдчилсан судалгаа хийж байна
4	656	Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг Төмөр замын тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн салбар дэд зөвлөлөөр 2025.09.04, 2025.11.12-нд 2 удаа хэлэлцүүлж, санал зөвлөмжийн дагуу ТЭЗҮ-д холбогдох сайржруулалт, нэмэлт өөрчлөлтийг тусгасны дагуу Зам, тээврийн яамны салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлээд байна.

5	663	Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан 6.9 км төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Хил дамнасан төмөр замын төслийн ажлын явцын талаар ЗГ-ын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын 2025.11.12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр төслийн ажлыг эрчимжүүлэхээр даалгасан. БНХАУ-ын Бээжин хотноо 2023 оны 10 дугаарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Бүс ба зам” дээд түвшний чуулга уулзалтын үеэр байгуулсан санамж бичгийн дагуу Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын Ажлын хэсэг байгуулахаар ЭЗХС-ын тушаалын төсөл, танилцуулгыг боловсруулж, ЗТС-ын 2025.12.04-ний өдрийн 01/5622 дугаар бичгээр хүргүүлээд байна.
6	695	Чойбалсан-Хөөт-Бичигт боомт чиглэлийн 426 км төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан “Түншлэлийн хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-ын дагуу Япон улсын “Ниппон кой” ХХК-ийн 2013 онд боловсруулсан Чойбалсан- Хөөт- Бичигт чиглэлийн төмөр замын “Инженерийн урьдчилсан зураг төсөл” /FEED/- ийн тайлангийн техникийн үзүүлэлт, ажлын тоо хэмжээнд тулгуурлан урьдчилсан үнэлгээ хийж, Зам, тээврийн яаманд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/372 дугаартай албан бичгээр ирүүлсэн. тус урьдчилсан үнэлгээг хянаж, эдийн засгийн тооцооллыг дахин сайжруулах чиглэлийг хүргүүлсэн.
<b>2. Иргэний нисэхийн салбар</b>				
7	644	Буйр нуур олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын “4С” ангилал бүхий нисэх буудал байгуулах;	Тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	ИНЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг Дорнод аймгийн Халхгол сумын “Сартуул худаг” орчимд нисэх буудал байгуулах байршлыг сонгосон. Энэхүү байршил нь “Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ”-нд заасан 25 км-т хамаарахгүй байгаа тул уг байршилд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4С хяналтын кодтой аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий нисэх буудал байгуулахад хамгийн тохиромжтой гэж дүгнэсэн.
8	654	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх	Улаанбаатар бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Тус барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025.04.11, 2025.05.20, 2025.08.01, 2025.10.03 -ны өдрүүдэд зарласан боловч бүгд амжилтгүй болсон. Иймд тендерийг дахин 11 сарын 13-ны өдөр зарлаж, 12 дугаар сарын 05-ны өдөр нээхээр төлөвлөсөн боловч удаа дараа амжилтгүй болсон шалтгаанаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлээд байсан эрхийг “ИНҮТ” ТӨХХК буцаан авч дээрх тендер хүчингүй болсон. Одоогоор тендерийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, шалгаруулалтыг

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

				ирэх долоо хоногт багтаан дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна.
<b>3. Авто замын салбар</b>				
9	60	"Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламж барих;	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	"Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл) -ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Зам, тээврийн яамнаас улсын төсвийн 28,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр нээсэн бөгөөд 8 оролцогч оролцсон боловч тендер хүчингүй болсон. - "Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл) -ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Зам, тээврийн яамнаас улсын төсвийн 23,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зарлаж, 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр нээсэн бөгөөд 7 оролцогч оролцсон боловч тендер хүчингүй болсон.
10	61	Хөшгийн хөндийн туннел барих;	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	Техник эдийн засгийн үндэслэл болон зураг төслийг хийж гүйцэтгэж байна.
11	116	Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлд 92.13 км хатуу хучилттай авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тухайн төсөл, арга хэмжээнд Зам, тээврийн сайдыг багцад 16,139.0 төсөвт өртөгтэй, 8,069.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр батлагдсан. ТХААГ-аас тендер зарласан, гүйцэтгэгч шалгараагүй байна.
12	660	Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км 6 эгнээ хатуу хучилттай авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Төслийн ТЭЗҮ хийгдсэн байсан боловч ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 эгнээ хатуу хучилттай зам гэж тусгасан байна. Иймд ТЭЗҮ-г шинэчлэх, баталгаажуулан ӨУХТ-н шаардлага хангах шаардлагатай болсон байна. Энэ тухай ЗТЯ-д 2025.04.29-ний өдөр мэдэгдсэн байна. ЗТЯ-аас төслийн нарийвчилсан зураг, төсөв өртгийг магадлангаар баталгаажуулан 2025.06.10-ны өдөр хариу ирүүлснээр төсөл хэрэгжүүлэх санал, хүсэлтийг Кувейтын санд хүргүүлсэн байна.
13	676	Улиастай-Алтай чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40 км авто замын барилгын ажлын нээлт 2025.05.05-ны өдөр хийгдсэн. Авто замын барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь. Үлдсэн 60 км авто замын зураг төслийн ажил хийгдэж дууссан. Магадлал хийгдэж байна.
14	677	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто зам барилгын ажлын тендер 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдөр зарлагдсан. 1-р багцын 191 дугаартай Гэрээ 2025.07.08-ны өдөр Захиалагч болон "Чайна Рөүд энд

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

				Бридж Корпорэйшн” компанийн хооронд байгуулсан. 2-р багцын 189 дугаартай Гэрээ 2025.07.08-ны өдөр Захиалагч болон “Лонжиан Рөүд энд Бридж” компанийн хооронд байгуулсан. 3-р багцын 188 дугаартай Гэрээ 2025.07.08-ны өдөр Захиалагч болон “Лонжиан Рөүд энд Бридж” компанийн хооронд байгуулсан. 2025.08.22-ны өдөр Зөвлөхөөс ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2025.09.05-ний өдрөөр гаргаж өгсөн. Дээрх 3 багцын гүйцэтгэгч нар зураг төсөл шинэчлэх ажлыг хийж байна.
15	693	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Есөнзүйл сум хүртэлх 16 км хатуу хучилттай авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Тус чиглэлийн авто замыг Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025.07.29-ний өдөр зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй. Иймд Дэлхийн банктай зөвшилцөн тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж дахин зарлахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
16	694	Архангай аймгийн Булган сум хүртэлх 35 км хатуу хучилттай авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Тус чиглэлийн авто замыг Дэлхийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн боловч зээлийн хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэл учирсан тул Дэлхийн банкны зүгээс түр хойшлуулах чиглэлийг өгсөн.

Хүснэгт №3-т туссан 16 төсөл, арга хэмжээний төмөр замын салбарын 6, иргэний нисэхийн салбарын 2, авто замын салбарын 8 төсөл, арга хэмжээг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-ийн дагуу үнэлэх боломжгүй байна.

2.4. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан 54 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэн, хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №4-т харуулав.

Төсөл, арга хэмжээний биелэлт  
(Хариуцсан газраар)

*Хүснэгт №4*

Газруудын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
БТГ	2	65%
АЗБЗГ	32	62.7%
ТЗТБЗГ	9	45.6%
ИНБЗГ	7	80%
АТБЗГ	4	100%
Нийт	54	65.3

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, эзэнжүүлээгүй байгаа тул үндсэн чиг үүргийн дагуу Хүснэгт №4-т заасан байдлаар үнэлэв.

2.5. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.5-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №5-т харуулав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ  
(Хариуцсан газраар)

Хүснэгт №5

Газруудын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
		85 хувь буюу түүнээс дээш "үр дүнтэй"	60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"	30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй"	0-29 хувь буюу "үр дүн гараагүй"	
БТГ	2	1	-	1	-	65%
АЗБЗГ	32	10	7	12	3	62.7%
ТЗТБЗГ	9	2	-	7	-	45.6%
ИНБЗГ	7	5	-	2	-	80%
АТБЗГ	4	4	-	-	-	100%
Нийт	<b>54</b>	<b>22</b>	<b>7</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>65.3</b>

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хариуцан хэрэгжүүлэх газар, нэгж, байгууллагыг тодорхой болгоогүй байгаа тул үндсэн чиг үүргийн дагуу Хүснэгт №5-д заасан байдлаар үнэлсэн.

### Гурав. Дүгнэлт

3.1. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ, хийх журам"-ын дагуу үнэлэхэд зам, тээврийн сайдын дангаараа хэрэгжүүлэх 54 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 65.3 хувь, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн өссөн дүн 45.9 хувийн үнэлгээтэй буюу **"үр дүн хүлээгдэж байгаа"**, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн нийт үнэлгээ 100 хувь, хөтөлбөрийн үр дүн 85.6 хувь, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 26 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.2 хувийн үнэлгээтэй буюу **"үр дүнтэй"** гэж үнэлэгдсэн.

3.2. Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч хасагдсан, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал хүргүүлсэн, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, ТЭЗҮ, зураг төслийн шатанд хэрэгжиж байгаа, санхүүжилт шийдвэрлэгдээгүй, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд төслийн шинжилгээ хийж байгаа энэхүү тайлангийн 2.3 дахь хэсэгт дурдсан барилгын ажил эхлээгүй 16 төсөл, арга хэмжээний "шалгуур үзүүлэлт"-ийг "барилгын ажлын гүйцэтгэл"-ийн хувиар тооцохоор батлуулсан нь тухайн бодлогын бичиг баримтын хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлж байна.

3.3. Бодлогын баримт бичгүүдийг батлуулахдаа уялдаа холбоог хангаагүй буюу зарим төсөл, арга хэмжээний 2025 онд хүрэх түвшинг "зөрүү"-тэй батлуулсан байна. Тухайлбал: *Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 691, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.8.3.16-д заасан авто замын салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 640, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.8.2.1, 1.8.2.2, 1.8.2.3, 1.8.2.5-д заасан иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ гэх зэрэг.*

3.4. Цаашид бодлогын баримт бичгүүдийг төсөлд санал хүргүүлэхдээ төлөвлөлтийг уялдуулах, "шалгуур үзүүлэлт", "зорилтот түвшин"-г бүтээн байгуулалтын ажлын явц болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлж үнэн зөв, бодитой тодорхойлж, салбарын хэмжээнд



биелэлтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна.

### **Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

#### **4.1. Бодлого, төлөвлөлтийн газарт:**

- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг “эзэнжүүлэх төлөвлөгөө”-г батлуулах;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Яам, Газрууд, Харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах;
- Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдэд туссан төсөл, арга хэмжээний “шалгуур үзүүлэлт”, “зорилтот түвшин” зэргийг уялдуулан хэрэгжилтийг бүрэн хангах ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулж 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор яамны удирдлагад танилцуулах;

#### **4.2. Яамны газар, хэлтсүүдэд:**

- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг яам, нэгж, харьяа байгууллага, албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах;
- Тайлангийн боловсруулалтад анхаарч, шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт болон үр дүнг нотлох баримтын хамт хавсарган иж бүрэн тайланг гаргаж, хянан баталгаажуулж Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлж ажиллах;
- Үр дүнд хүрээгүй зорилт арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тайланд үнэн зөв дурдах;
- Төсөл, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах;
- Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ын 6 дугаар хавсралтад заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж ажиллахыг тус тус зөвлөж байна.

---oOo---